

# БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Булган сумын 3-р цэцэрлэгийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БУА-2024/179/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Булган аймаг

2024 он

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ

Утас: 70342580 Цахим хаяг: [erdeneb@audit.gov.mn](mailto:erdeneb@audit.gov.mn)

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: 70342716 Цахим хаяг: [enkhtsoodolj@audit.gov.mn](mailto:enkhtsoodolj@audit.gov.mn)

“Бэйкер Тилли Далайван Аудит” ХХК-ийн Орхон аймаг дахь салбарын захирал: Д.Мягмарсүрэн

Утас: 99030170 Цахим хаяг: [dalaivan.orkhon@gmail.com](mailto:dalaivan.orkhon@gmail.com)

“Бэйкер Тилли Далайван Аудит” ХХК-ийн Орхон аймаг дахь салбарын Аудитор: Б.Пүрэвсүрэн

Утас: 99921600 Цахим хаяг: [dalaivan.orkhon@gmail.com](mailto:dalaivan.orkhon@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082  
Утас/Факс: 7034-2580  
E-mail: bulgan@audit.gov.mn

2024.02.23 № 161  
танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

БУЛГАН СУМЫН 3 ДУГААР  
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
Б.МӨНХЦЭЦЭГ ТАНАА

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын 3 дугаар цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган сумын 3 дугаар цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдсэн ба улсын төсвөөс 304,962.3 мянган төгрөгийн санхүүжилт, орон нутгийн төсвөөс 20,200.0 мянган төгрөгийн нийт 325,162.3 мянган төгрөгийн санхүүжилт авсан нь өмнөх онтой харьцуулахад 125,714.1 төгрөгөөр буюу 52.8 хувиар өссөн байна.

#### Аудитын гол асуудал

Боловсролын байгууллага гүйцэтгэлд суурилсан төсвөөр санхүүжүүлэх болсноор сургуулийн өмнөх боловсрол олгох хөтөлбөрөөс хэрэгжүүлэх арга хэмжээ 6 болж зардлын зүйл анги багасаж, ихэнх зардал бараа үйлчилгээний бусад зардлаас зарцуулах болсон байна.

Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд гурван зорилтын хүрээнд хорин дөрвөн арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, батлуулсан бөгөөд

006020371

гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 94.0 хувийн биелэлтэйгээр дүгнэгдсэн байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	74,875,431.00	108,672,504.02
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	20,438,224.00	47,891,117.02
312	Банканд байгаа бэлэн мөнгө	20,438,224.00	47,891,117.02
3121	Төгрөг	20,438,224.00	47,891,117.02
31211	Төрийн сангийн харилцах	20,438,224.00	47,891,117.02
35	БАРАА МАТЕРИАЛ	54,437,207.00	60,781,387.00
351	Түүхий эд материал		9,922,940.00
3511	Тусгай зориулалттай материал		9,922,940.00
354	Хангамжийн материал	54,437,207.00	50,858,447.00
3541	Бичиг хэргийн материал	1,161,220.00	983,520.00
3542	Аж ахуйн материал	9,814,190.00	12,599,590.00
3543	Сэлбэг хэрэгсэл	8,568,590.00	
3544	Түлш, шатах тослох материал	1,500,100.00	172,250.00
3545	Барилгын засварын материал	11,000.00	1,056,050.00
3546	Хүнсний материал	3,845,332.00	5,323,262.00
3547	Бусад хангамжийн материал	29,536,775.00	30,723,775.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	106,849,165.34	110,078,354.92
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	106,849,165.34	110,078,354.92
392	Биет хөрөнгө	87,905,790.34	91,388,104.92
39201	Барилга, байгууламж, орон сууц	69,313,688.84	69,313,688.84
39202	Хуримтлагдсан элэгдэл	(14,794,717.65)	(17,739,344.13)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	31,892,530.00	32,872,030.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(22,191,840.10)	(25,186,223.90)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	28,639,706.00	38,915,706.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(10,006,795.75)	(12,570,970.89)
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,800,000.00	2,800,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(240,000.00)	(510,000.00)
39217	Ном	3,493,219.00	3,493,219.00
393	Биет бус хөрөнгө	18,943,375.00	18,690,250.00
39301	Программ хангамж	1,750,000.00	1,750,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(990,625.00)	(1,243,750.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	18,184,000.00	18,184,000.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	181,724,596.34	218,750,858.94
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР		13,680,300.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		13,680,300.00
413	Өглөг		13,680,300.00
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг		704,300.00
4136	Бусад өглөг		12,976,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг		12,976,000.00
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	181,724,596.34	205,070,558.94
51	Засгийн газрын хувь оролцоо	181,724,596.34	205,070,558.94

Булган аймгийн Булган сумын 3-р цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	38,841,469.00	38,841,469.00
51101	Өмч: - төрийн	18,184,000.00	18,184,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	80,722,728.39	104,068,690.99
5121	Өмнөх үеийн үр дүн	80,722,728.39	80,722,728.39
5122	Тайлант үеийн үр дүн		23,345,962.60
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	62,160,398.95	62,160,398.95
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	181,724,596.34	218,750,858.94

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	201,741,200.00	330,804,250.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,293,000.00	5,641,950.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,293,000.00	5,641,950.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,800,000.00	1,979,500.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	493,000.00	3,662,450.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	199,448,200.00	325,162,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	173,831,300.00	304,962,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	173,831,300.00	304,962,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	25,616,900.00	20,200,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	25,616,900.00	20,200,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	191,940,596.87	307,458,287.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	191,940,596.87	307,458,287.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	191,940,348.87	306,896,801.08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	130,171,915.00	220,141,925.54
210101	Үндсэн цалин	102,395,816.00	167,437,654.54
210102	Нэмэгдэл	21,033,878.00	45,871,474.00
210104	Урамшуулал	6,742,221.00	6,832,797.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,271,081.00	28,241,531.44
210201	Тэтгэврийн даатгал	11,105,214.53	19,432,413.29
210202	Тэтгэмжийн даатгал	1,305,858.49	2,302,366.07
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,044,706.01	1,771,492.93
210204	Ажилгүйдлийн даатгал	250,070.43	416,836.85
210205	Эрүүл мэндийн даатгал	2,565,231.54	4,318,422.30
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,498,182.00	17,669,863.68
210301	Гэрэл, цахилгаан	1,541,242.00	1,872,188.24
210302	Түлш, халаалт	9,728,940.00	15,301,850.00
210303	Цэвэр, бохир ус	228,000.00	495,825.44
2104	Хангамж, бараа материалын зардал	605,000.00	151,000.00

Булган аймгийн Булган сумын 3-р цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	101,000.00	
210408	Бараа материал акталсны зардал	504,000.00	151,000.00
2105	Норматив зардал	12,672,906.00	20,550,270.00
210502	Хоол, хүнс	12,672,906.00	20,550,270.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	675,500.00	2,547,700.00
210604	Урсгал засвар	675,500.00	2,547,700.00
2107	Томилолт, зочны зардал		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	292,200.00	426,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	292,200.00	426,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,753,564.87	17,167,710.42
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,037,990.00	6,343,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,582,400.00	1,798,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	15,133,174.87	9,026,310.42
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	248.00	561,486.32
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	248.00	
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	248.00	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт		561,486.32
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		561,486.32
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	9,800,603.13	23,345,962.60
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	138,887.45	
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	138,887.45	
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(138,887.45)	
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	9,661,715.68	23,345,962.60

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	199,448,200.00	325,162,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	199,448,200.00	325,162,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	173,831,300.00	304,962,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	173,831,300.00	304,962,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	25,616,900.00	20,200,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	25,616,900.00	20,200,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	179,009,976.00	297,709,406.98
21	УРСГАЛ ЗАРДАЛ	179,009,976.00	297,709,406.98
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	179,009,728.00	297,147,920.66
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	130,156,018.82	219,428,441.66
210101	Үндсэн цалин	102,379,919.82	158,802,591.66

Булган аймгийн Булган сумын 3-р цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

210102	Нэмэгдэл	21,033,878.00	53,793,053.00
210104	Урамшуулал	6,742,221.00	6,832,797.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,286,977.18	28,278,515.32
210201	Тэтгэврийн даатгал	11,121,110.71	19,532,549.76
210202	Тэтгэмжийн даатгал	1,305,858.49	2,302,366.07
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,044,706.01	1,771,492.93
210204	Ажилгүйдлийн даатгал	250,070.43	416,836.85
210205	Эрүүл мэндийн даатгал	2,565,231.54	4,255,269.71
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,443,742.00	16,342,013.68
210301	Гэрэл, цахилгаан	1,541,242.00	1,872,188.24
210302	Түлш, халаалт	8,674,500.00	13,974,000.00
210303	Цэвэр, бохир ус	228,000.00	495,825.44
2104	Хангамж, бараа материалын зардал	101,000.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	101,000.00	
2105	Норматив зардал	15,106,080.00	21,323,900.00
210502	Хоол, хүнс	15,106,080.00	21,323,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	599,000.00	3,296,500.00
210604	Урсгал засвар	599,000.00	3,296,500.00
2107	Томилолт, зочны зардал		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	292,200.00	489,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	292,200.00	489,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,024,710.00	7,989,350.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,524,810.00	6,521,750.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,499,900.00	1,467,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	248.00	561,486.32
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	248.00	
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	248.00	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт		561,486.32
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		561,486.32
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	20,438,224.00	27,452,893.02
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	20,438,224.00	27,452,893.02
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		20,438,224.00
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		47,891,117.02

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
-----	----------	--------------------	-----------------------	----------------------	-------------------------

Булган аймгийн Булган сумын 3-р цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

1	2021 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл	38,841,469.00	62,160,398.95	71,061,012.71	172,062,880.66
7	Тайлант үеийн үр дүн			9,661,715.68	9,661,715.68
10	2022 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл	38,841,469.00	62,160,398.95	80,722,728.39	181,724,596.34
17	Тайлант үеийн үр дүн			23,345,962.60	23,345,962.60
19	2023 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл	38,841,469.00	62,160,398.95	104,068,690.99	205,070,558.94

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	294,536,900.00	297,709,406.98	-3,172,506.98	101.08
21	УРСГАЛ ЗАРДАЛ	294,536,900.00	297,709,406.98	-3,172,506.98	101.08
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	294,536,900.00	297,147,920.66	-2,611,020.66	100.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	215,782,200.00	219,428,441.66	-3,646,241.66	101.69
210101	Үндсэн цалин	140,675,400.00	158,802,591.66	18,127,191.66	112.89
210102	Нэмэгдэл	70,755,400.00	53,793,053.00	16,962,347.00	76.03
210104	Урамшуулал	4,351,400.00	6,832,797.00	-2,481,397.00	157.03
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,204,000.00	28,278,515.32	5,925,484.68	82.68
210201	Тэтгэврийн даатгал	23,360,000.00	19,532,549.76	3,827,450.24	83.62
210202	Тэтгэмжийн даатгал	2,748,000.00	2,302,366.07	445,633.93	83.78
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,049,900.00	1,771,492.93	278,407.07	86.42
210204	Ажилгүйдлийн даатгал	549,700.00	416,836.85	132,863.15	75.83
210205	Эрүүл мэндийн даатгал	5,496,400.00	4,255,269.71	1,241,130.29	77.42
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,580,000.00	16,342,013.68	-2,762,013.68	120.34
210301	Гэрэл, цахилгаан	2,480,000.00	1,872,188.24	607,811.76	75.49
210302	Түлш, халаалт	10,650,000.00	13,974,000.00	-3,324,000.00	131.21
210303	Цэвэр, бохир ус	450,000.00	495,825.44	-45,825.44	110.18
2105	Норматив зардал	20,005,400.00	21,323,900.00	-1,318,500.00	106.59
210502	Хоол, хүнс	20,005,400.00	21,323,900.00	-1,318,500.00	106.59
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,800,000.00	3,296,500.00	-496,500.00	117.73
210604	Урсгал засвар	2,800,000.00	3,296,500.00	-496,500.00	117.73
2107	Томилолт, зочны зардал				
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	435,300.00	489,200.00	-53,900.00	112.38

Булган аймгийн Булган сумын 3-р цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	435,300.00	489,200.00	-53,900.00	112.38
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,730,000.00	7,989,350.00	-259,350.00	103.36
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,262,400.00	6,521,750.00	-259,350.00	104.14
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,467,600.00	1,467,600.00		100
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		561,486.32	-561,486.32	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох		561,486.32	-561,486.32	
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		561,486.32	-561,486.32	
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	345,594,500.00	325,162,300.00	20,432,200.00	94.09
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	325,394,500.00	304,962,300.00	20,432,200.00	93.72
131001	Улсын төсвөөс санхүүжих	325,394,500.00	304,962,300.00	20,432,200.00	93.72
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	20,200,000.00	20,200,000.00		100
132001	Орон нутгийн төсвөөс	20,200,000.00	20,200,000.00		100
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		20,438,224.00	20,438,224.00	-
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		47,891,117.02	47,891,117.02	-

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 136.3 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс, 49.5 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 86.7 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

#### 3.1 Төлбөрийн акт

Цэцэрлэгийн бараа материалд биет тооллого хийхэд 49,500.0 (дөчин есөн мянга таван зуун ) төгрөгийн засварын бараа материал дутагдсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.2-т "Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх" , 5.1.5.-т "Хариуцлагатай байх." гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байгаа нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### 3.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөөгүй.

#### 3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 1. Зардлын данстай холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Тайлангийн хугацаанд цалингийн зардлаас 86.7 мянган төгрөгийг ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 22.6.7-д “Төсвийн шууд захирагч нь батлагдсан төсвийг энэ хуулийн 22.2.3-22.2.6-д заасан ангиллаар бүртгэж, тайлагнах”, Монгол Улсын Сангийн Сайдын 2021 оны 190-р тушаалыг зөрчиж байгаа нь нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул зөвлөмж хүргүүлж байна.

**Өгсөн зөвлөмж:** Цаашид цалин хөлсийг тооцохдоо холбогдох хууль тогтоомжийг баримтлах

## 2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн тэг үлдэгдэлтэй 22 нэр төрлийн 43 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7 дугаар зүйлийн 7.1-д “Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ.” гэсэн заалт зөрчигдөж байгаа нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

**Өгсөн зөвлөмж:** Цаашид холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 06 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо
Цалин хөлстэй холбоотой	1	86.7					1	86.7					
Үндсэн хөрөнгөтэй холбоотой	1	-					1	-					
Бараа материалтай холбоотой	1	49.5	1	49.5									
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>136.2</b>	<b>1</b>	<b>49.5</b>			<b>2</b>	<b>86.7</b>					

Булган аймгийн Булган сумын 3-р цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
2 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн	1						1	
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Нийт дүн	1	-					1	-

**5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалта	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			